

Баянхонгор аймаг дахь
Цагдааагийн газрын сэктэл зүйч М.Одонгоо

Бидэнд тэр хэрэггүй

Хүнд хэрэггүй зүйл гэж бараг байхгүй мэт хүний хэрэгцээ гэж хязгааргүй байдаг энэ бол эдийн засгийн хууль. Гэвч орчлон хорвоо дээр ашиглах шаардлагагүй хүний хэрэгцээний жагсаалтаас нэг мөсөн устгах хэрэгтэй зарим нэг зүйлс байх юм. Энэ бол “Авлигын хар аалзны тор” юм. Өнөөдрийн манай нийгэмд тулгараад байгаа энэхүү авлигын асуудалыг хүн бүр өөр өөрсдийнхөөрөө дүгнэн үзэл бодлоо илэрхийлдэг. Бие хүн болон нийгмийн бүлгүүдийн хувьд авлигал нь нийгмийн нөгөө талд, далд өртөнцөд үргэлж нийгмийн гүн рүү шигдсээр ирсэн. Авлигын эсрэг тэмцэж дүрэм журам, хууль гаргах тусам тэрний оршин тогтонох арга зүй улам нарийн төвөгтэй, далд хэлбэрт шилжиж байгаа нь нууц биш.

Ард түмний дунд хар хэллэгээр авлигыг “гар хүндрүүлэх” хэмээн нэрлэх болж. Өнөөдөр хувь хүн ямарваа нэгэн ажил хэргийг бүтээхийн тулд заавал гар хүндрүүлэх буюу авлига өгөх шаардлагатай тулгардаг. Хамгийн энгийн бодит жишээ бол хувь хүн эмнэлэгт шинжилгээ өгөх, хагалгаа хийлгэх, төрөх гээд аль ч үйлчилгээг авахын тулд асрагч, сувилагчаас нь эхлээд бүгдэнд нь гар цайлгах зүйл өгөх шаардлагатай зайлшгүй тулгардаг гэж хүн бүр ярьдаг. Гэхдээ сүүлийн үед төрийн байгууллагуудын албан хаагчдын авлигад өртөх нь харьцангуй багассан ч хувийн хэвшил болон төрийн өндөр дээд албан тушаалтнуудыг хүнд суртал, авлигаас ангид болох талаар ард иргэд ярьж байна.

“Авлига” гэж чухам юу вэ? ёс бусаар шунаж авсан эд юмс, эрх мэдэл, давуу байдлыг хэлнэ. Харин 2006 онд батлагдсан Монгол улсын авлигын эсрэг хуулийн 3.1.1-д ингэж тодорхойлсон байдаг “авлига” гэж энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан тушаалын эрх мэдлээ хувийн ашиг хонжоо олоход урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох, иргэн, хуулийн этгээдээс тэрхүү хууль бус давуу байдлыг олж авах үйлдэл, эс үйлдэхүйгээр илрэх аливаа эрх зүйн зөрчлийг хэлнэ гэж заасан байна. Авлига гэх зүйл чухам хэдий үеэс ямар байдлаар яагаад үүсэн гэдгийг хэн ч мэдэхгүй.

Миний бодлоор авлига анх ийм байдлаар үүсэн байх. Хүн төрөлхтөн их зальжин тийм ч учраас бусад амьтны аймгаас ялгарч дээд оюун ухаант төрөл гэж нэрлэгддэг. Тэд өөрсдийн амьдралыг амар хялбар байлгах арга хэлбэрийг үргэлж эрэлхийлж байдаг. Ингээд амар хялбар амьдарлын төлөө бяцхан заль “Хайр”, “Талархал”, “Хүндэтгэл” гэх зэрэг гоёмсог нэрийн дор алтан түлхүүртэй нээлттэй хаалгыг бий болгохыг хичээдэг. Энэ нь бас буруутгах явдал биш юм. Бид бүгд л сайн сайханы төлөө тэмүүлдэг. Гагцхүү түүнд хүрэх арга зам нь хүн бүрт өөр өөр байдаг.

“Хайр, талархал, хүндэтгэл”-ээ илэрхийлэх нэрийн дор бяцхан шан, гарын бэлэг өгч ажлаа бүтээх, нөгөө хүн нь бусдын хайр, хүндэтгэлийг авахгүй байж болохгүй мэт дүр эсгэх за тэгээд бусдын хайр хүндэтгэлийг авсан хүн чинь яаж туслахгүй байхав. Амар хялбар амьдралын эргэх холбоос бүхий алтан дүрэм нь ердөө л энэ. Гэхдээ энэ бол амьдрах зөв зам биш гэдгийг хүн бүр хэлэх биз. Чухамдаа авлига гэх зүйл яагаад бий болсон, юунаас болоод улам хөгжөөд байгааг бид өөрсдөө ч мэддэггүй. Сайны хажуугаар саар гэж нийгмийн хөгжил дэвшил, хурдацтай хөгжих даяршлын эрин зуунд дэлхийн улсуудын үйл явцын хажуугаар “Авлига” гэх нэгэн шинэ нэр томъёо яг хэдий үеэс гарч ирснийг тогтоосон онол, үзэл баримтлал гэж байхгүй.

Харин сүүлийн жилүүдэд дэлхий нийтээрээ авлигатай хүчтэй тэмцэж, хүн болгон дуу хоолойгоо нэгтгэх болж. Үүний нэгэн адил Монгол улс ч гэсэн дэлхий нийттэй хөл нийлүүлэн алхаж эрүүл нийгмийн төлөө хүн бүр гар бие оролцох болсон байна. “Авлигын эсрэг хууль”-н

6.1.3.төрийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах

6.1.6.төрийн албан хаагч бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох, эрхэлж байгаа ажлын онцлогтой нь холбогдуулж түүнд хориглох зүйлийг Төрийн албаны тухай хууль болон энэ хуульд заасны дагуу тогтоон мөрдүүлэх

6.1.7.төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд тавих хяналтад төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж, хамтран ажиллах, мэдээллийг харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх гэж заасан байдаг. Хууль тогтоомжид заасан эдгээр дүрэм журмуудыг зөрчихгүй байхад л бид авлигын хар сүүдэрт өртөхгүй байж эрүүл нийгмийг цогцлоон бүтээх бүрэн боломжтой юм.

Бид бүгд авлига өгч, авах нь зөв зүйтэй зүйл явч биш гэдгийг мэддэг атлаа ертөнцийн өгч, авахын дүрмийг дагаж байна хэмээн өөрсдийгөө өмөөрч авлига гэх аалзны торыг улам бат бөх болгон сүлжсээр байлаа.

Монголчууд эрт үеэсээ шудрага үнэнч, тууштай няцашгүй тэмцэгч ард түмэн гэдгээрээ дэлхийд үнэлэгддэг. Жишээлбэл: Монголын нууц товчооноо Агуу их Богд Чингис хаан алтан ногт газар тавьж ардуудын дундаас өөрийн үнэнч цэргийг сонгосон тухай гардаг. Түүн дээр Чингис хаанд надад цэргийн эрдэм төгс олон баатар эрс бий харин өөрийн дэргэд байх шудрага үнэнч нэгнийг хүсэх бөгөөд энэ нь цаашид улсыг төвшитгөхөд нэн чухал гэсэн утга бүхий хэсэг байдаг. Ирээдүй хойч үе нь болсон бид одоо энэхүү үйл хэргийг нь үргэлжлүүлж өөрсдийн амьдарч буй нийгмийг эрүүл байлгахын тулд тууштай тэмцэж байгаа билээ.

Жишээлбэл: Монгол улсын Мянганы хөгжлийн 9 дэх зорилгын “Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, 24 дүгээр зорилт”-ын “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” дэд зорилго зэрэг томоохон авлигын эсрэг үйл хэргийг хэрэгжүүлж байна. Баянхонгор аймаг 2013 онд авлигын индекс 0.59, авлигад өртөх эрсдлээрээ 0.41%-тай явж байна.

Авлигатай тэмцэж буй хамгийн энгийн жишээ Баянхонгор аймагт болон бусад аймгуудад төрийн бүх байгууллагууд ард иргэдээ уриалах, зөв үзэл бодолыг төрүүлэх зорилгоор хаалган дээрээ “Та авлигагүй бүсэд нэвтэрлээ” гэсэн уриаг байрлуулсан байна. Энэ мэт авлигын эсрэг олон ажлуудыг хийж байгаа нь ард түмэнд хүрч байна.

Монгол улс Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.13т заасны дагуу Монгол улсын Авлигатай тэмцэх газар авлигын хэлбэр, цар хүрээ, шалтгааныг 2 жил тутамд судлан авлигын индексийг тооцон олон нийтэд мэдээлдэг. Монгол улс 2009 – 2013 хооронд 2 жилийн харьцуулсан байдлаар шинжээчдын төсөөллөөрх хувь хэмжээ 2009 онд 0.11 байсан бол 2013 онд 0.09 болон буурсан ахицтай байгаа нь цаашдаа бид “Авлигын эсрэг хамтдаа” байвал энэхүү нийгмийн хар сүүдэрийг бүр мөсөн устгах бүрэн боломжтой гэдгийг харуулж байгаа хэрэг юм.

Эцэст нь Монгол улс хууль дүрмийн хүрээнд болон нийгмийн үйл ажиллагааны хүрээнд авлигатай хүчтэй тэмцэж түүний эсрэг олон хууль дүрэм, эрх зүйн актуудыг мөрдүүлдэг. Энэ нь ч үр дүнгээ өгч төрийн байгууллагуудын албан хаагчдыг авлигаас ангид болгож байгаа дэвшил гарч байгаа нь сайшаалтай. Гэвч авлигыг ул мөргүй устгахад зөвхөн дүрэм журам мөрдөх нь төдийлөн хурдацтай ахих зам биш юм. Харин ард иргэдийн сэтгэхүйд нөлөөлсөн, үзэл бодлыг нь өөрчилсөн үйл ажиллагаа, нийгмийн төсөлт хөтөлбөрүүд, аян, кино зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь илүү үр дүнтэй гэж бодож байна. Тухайлбал: дээр дурьдсанчлан “Та авлигагүй бүсэд нэвтэрлээ” гэх мэт сурталчилагаа, зурагт хуудас болон ерөнхий боловсролын сурагчдад цуврал хичээл заах зэрэг ажлуудыг хийх нь авлигаас урьдчилан сэргийлэх болно.

Монголчууд эвтэй байхдаа хүчтэй гэж сайхан уриа бий тэгвэл авлигын эсрэг хамтдаа байж чадвал түүнийг бид нийгэмд хэрэггүй зүйл болгон, далд өртөнцөөс ил гаргаж үгүй хийж чадна гэдэгт би итгэлтэй байна... “Авлигын эсрэг хамтдаа”